

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
САГ	Санхүүгийн Аудитын Газар
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
ТХН	Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж
ААНОАТ	Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татвар
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
ХШҮ	Хяналт Шинжилгээ Үнэлгээ

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

ТӨСӨВ САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Д.БАТМӨНХ ТАНАА

2021.02.25 № 07/521
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төслийн удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Төслийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бүрэлдэхүүн хэсгийн нийт 256 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Төслийн удирдах хороогоор батлуулснаас төлөвлөгөөний гүйцэтгэл 92 хувьтай байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,854,578,498.61</u>	<u>1,809,246,535.23</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,854,578,498.61	1,809,246,535.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,854,578,498.61	1,809,246,535.23
3121	Төгрөг	516,024,160.72	1,082,248,284.91
31211	Төрийн сангийн харилцах	516,024,160.72	1,082,248,284.91
3122	Гадаад валют	1,338,554,337.89	726,998,250.32
31223	Арилжааны банк дахь харилцах	1,338,554,337.89	726,998,250.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,115,882.82</u>	<u>55,322,559.59</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,115,882.82	55,322,559.59
392	Биет хөрөнгө	8,902,966.15	51,977,142.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,997,934.00	62,667,714.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4,026,945.64)	(19,502,900.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,742,950.37	11,918,050.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	(810,972.58)	(3,105,720.74)
393	Биет бус хөрөнгө	6,212,916.67	3,345,416.67
39301	Програм хангамж	11,470,000.00	11,470,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,257,083.33)	(8,124,583.33)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,869,694,381.43</u>	<u>1,864,569,094.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,398,600.00</u>	<u>31,903,663.17</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,398,600.00	31,903,663.17
413	Өглөг	2,398,600.00	31,903,663.17
4136	Бусад өглөг	2,398,600.00	31,903,663.17
41361	Байгууллагад төлөх өглөг	2,398,600.00	-
41363	Татварын өглөг	-	31,903,663.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,867,295,781.43</u>	<u>1,832,665,431.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,867,295,781.43	1,832,665,431.66
512	Хуримтлагдсан үр дүн	1,867,295,781.43	1,832,665,431.66
51210	Өмнөх үеийн үр дүн	1,586,039,722.46	1,867,295,781.43
51220	Тайлант үеийн үр дүн	281,256,058.97	(34,630,349.77)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,869,694,381.43</u>	<u>1,864,569,094.83</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,088,616,146.66	7,355,953,668.45
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,088,616,146.66	7,355,953,668.45
120	Нийтлэг татварын бус орлого	6,088,616,146.66	7,355,953,668.45
120002	Хүүгийн орлого	13,043,551.18	2,830,663.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,075,572,595.48	7,353,123,004.73
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	95,300.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,075,572,595.48	7,353,027,704.73
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,819,617,972.43	6,031,845,636.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,819,617,972.43	6,031,845,636.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,819,617,972.43	6,031,845,636.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	294,663,810.00
210101	Үндсэн цалин	-	294,663,810.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	34,297,500.00
210201	Тэтгэврийн даатгал	-	34,297,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,198,750.00	41,478,000.00
210304	Байрны түрээс	24,198,750.00	41,478,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,270,866.35	23,345,791.61
210401	Бичиг хэрэг	37,729,493.00	6,692,626.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,541,373.35	16,653,165.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,385,176,673.53	5,617,422,331.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,385,176,673.53	5,617,422,331.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	359,971,682.55	20,638,203.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	359,971,682.55	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	20,638,203.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	268,998,174.23	1,324,108,031.79
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	12,257,884.74	9,809,276.93
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	12,257,884.74	9,809,276.93
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,368,547,658.49
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	-	1,368,547,658.49
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	12,257,884.74	(1,358,738,381.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	281,256,058.97	(34,630,349.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>6,088,616,146.66</u>	<u>7,355,953,668.45</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,088,616,146.66	7,355,953,668.45
120	Нийтлэг татварын бус орлого	6,088,616,146.66	7,355,953,668.45
120002	Хүүгийн орлого	13,043,551.18	2,830,663.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,075,572,595.48	7,353,123,004.73
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	95,300.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,075,572,595.48	7,353,027,704.73
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>5,474,688,014.88</u>	<u>6,032,563,970.27</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,474,688,014.88	6,032,563,970.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,474,688,014.88	6,032,563,970.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	228,473,884.00
210101	Үндсэн цалин	-	228,473,884.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	47,733,540.00
210201	Тэтгэврийн даатгал	-	47,733,540.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,198,750.00	37,200,000.00
210304	Байрны түрээс	24,198,750.00	37,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,270,866.35	23,345,791.61
210401	Бичиг хэрэг	37,729,493.00	6,692,626.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,541,373.35	16,653,165.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,382,778,073.53	5,695,810,754.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,382,778,073.53	5,695,810,754.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,440,325.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,440,325.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>613,928,131.78</u>	<u>1,323,389,698.18</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	332,436,356.00	1,378,530,938.49
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	332,436,356.00	1,378,530,938.49
2200	Дотоод эх үүсвэрээр	332,436,356.00	1,378,530,938.49
222001	Тоног төхөөрөмж	332,436,356.00	1,378,530,938.49
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(332,436,356.00)</u>	<u>(1,378,530,938.49)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	12,257,884.74	9,809,276.93
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	12,257,884.74	9,809,276.93
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>12,257,884.74</u>	<u>9,809,276.93</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	293,749,660.52	(45,331,963.38)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,560,828,838.09	1,854,578,498.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,854,578,498.61	1,809,246,535.23

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,586,039,722.46	1,586,039,722.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	281,256,058.97	281,256,058.97
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,867,295,781.43	1,867,295,781.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,867,295,781.43	1,867,295,781.43
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(34,630,349.77)	(34,630,349.77)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,832,665,431.66	1,832,665,431.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,794,649,800.00	7,411,094,908.76	383,554,891.24	95.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,031,972,400.00	6,032,563,970.27	(591,570.27)	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,031,972,400.00	6,032,563,970.27	(591,570.27)	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,473,900.00	228,473,884.00	16.00	100.0
210101	Үндсэн цалин	228,473,900.00	228,473,884.00	16.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,275,300.00	47,733,540.00	5,541,760.00	89.6
210201	Тэтгэврийн даатгал	53,275,300.00	47,733,540.00	5,541,760.00	89.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,200,000.00	37,200,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	37,200,000.00	37,200,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,345,800.00	23,345,791.61	8.39	100.0
210401	Бичиг хэрэг	6,692,600.00	6,692,626.00	(26.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,653,200.00	16,653,165.61	34.39	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,689,677,400.00	5,695,810,754.66	(6,133,354.66)	100.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,689,677,400.00	5,695,810,754.66	(6,133,354.66)	100.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,762,677,400.00	1,378,530,938.49	384,146,461.51	78.2
2200	Дотоод эх үүсвэрээр	1,762,677,400.00	1,378,530,938.49	384,146,461.51	78.2
222001	Тоног төхөөрөмж	1,762,677,400.00	1,378,530,938.49	384,146,461.51	78.2
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,353,027,704.72	7,353,123,004.72	(95,300.00)	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,353,027,704.72	7,353,123,004.72	(95,300.00)	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	95,300.00	(95,300.00)	
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,353,027,704.72	7,353,027,704.72	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,854,578,498.61		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,809,246,535.23		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6	-	
620001	Удирдах ажилтан	1	1	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	5	5	-	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн зохицуулагч Д.Батмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гадаад валютын ханшаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг зөв ханш ашиглан бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Грант Торнтон Аудит ХХК-ийн Ерөнхий захирал, гэрээт ажлын партнер Б.Осоргарав, Партнер, чанарын хянагч Н.Эрдэнэцог, аудитын менежер Б.Дэлгэрмаа, аудитор Э.Шижиртунгалаг, туслах аудитор Э.Номинтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 21 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл (6084-MN, 6085-MN) нь Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн байгуулсан байгуулсан зээлийн гэрээний дагуу нийт 8.8 сая ЗТЭ (SDR) буюу 12.0 сая ам. Долларын (P161048) санхүүжилттэй болно. Төсөл нь Монгол Улсад 2017 оны 9-р сарын 11-ний өдрөөс 2022 оны 1-р сарын 31-ний хооронд хэрэгжинэ. Төслийн зорилго нь төсөв, санхүү, нийгмийн хамгааллын салбарын хууль эрх зүйн орчин, төсвийн зарлагын удирдлагын чанар, төсвийн сахилгыг бэхжүүлэх болно.

Төсөл нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэх дэд зорилтын хүрээнд дараах 5 бүрэлдэхүүн хэсгүүдэд чиглэн үйл ажиллагаагаа явуулдаг байна. Үүнд:

- Бүрэлдэхүүн А - Макро эдийн засаг болон Төсвийн удирдлагыг бэхжүүлэх
- Бүрэлдэхүүн В - Улсын санхүүгийн удирдлагын үр ашгийг дээшлүүлэх
- Бүрэлдэхүүн С - Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг сайжруулах
- Бүрэлдэхүүн D - Нийгмийн хамгааллын системийг бэхжүүлэх
- Бүрэлдэхүүн Е - Төслийн удирдлага ба Хяналт шинжилгээ

2020 онд төслийн хүрээнд дараах онцлох ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтын үр ашигтай байдлыг хангах, гадаад хөгжлийн санхүүжилтийн үйл ажиллагааг бэхжүүлэх хүрээнд зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг удирдах, хянах үйл ажиллагааг автоматжуулах, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх програм хангамжуудыг хөгжүүлэн ашиглалтанд нэвтрүүлж эхлэсэн.
- Улсын салбарын дотоод аудитын тогтолцоог бэхжүүлэх, дотоод аудиторчуудын чадавхыг бэхжүүлэх хүрээнд “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, “Чанарын

үнэлгээний аргачлал” болон “Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг” зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэвлэн нийтэлж, эдгээр баримт бичгүүдийн хүрээнд улсын салбарын дотоод аудитуудад дотоод сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. Түүнчлэн 2017 онд шинэчлэгдсэн дотоод аудитын олон улсын стандартыг Монгол хэлнээ хөрвүүлж, хэвлэн нийтэлж улсын салбарын дотоод аудитуудад хүргүүлэх ажлыг хийсэн.

- Төсвийн зарлагын сахилга батыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд нэгдсэн төсвийн урсгал зардлын 20 гаруй хувийг бүрдүүлдэг төрийн албан хаагчдын цалин хөлсний талаарх мэдээллийн нэгдсэн сан бий болгох, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, цалин хөлс, орон тооны талаар бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай найдвартай эх үүсвэрийг бүрдүүлэх үүднээс Төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системийг хөгжүүлэн туршилтын нэвтрүүлэлтийг 21 аймгийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн байна.
- Банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, чанаргүй зээлийн хувь хэмжээг бууруулах хүрээнд зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны найдвартай байдал, техникийн чадавхыг сайжруулахад зориулан Монгол банкны зээлийн мэдээллийн санд сүлжээний оптикал свич болон галт ханыг худалдан авч, нийлүүлсэн. Ингэснээр, зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа 24/7 горимоор тасралтгүй найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан байна.

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 онд төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг тооцох суурь үзүүлэлтээр сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 06 дугаар сарын 30-ны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,776,655.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 27,766.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны 12 дугаар сарын 31-ны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн

нийт зардлын хэмжээ 7,400,393.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 74,003.9 мянган төгрөг болгон өөрчилсөн.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,125.3 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөг)			
Үзүүлэлт	2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,854,578.5	1,809,246.5	(45,332.0)
Үндсэн хөрөнгө	15,115.9	55,322.6	40,206.7
Нийт хөрөнгө	1,869,694.4	1,864,569.1	(5,125.3)
Өр төлбөр	2,398.6	31,903.7	29,505.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,867,295.8	1,832,665.4	(34,630.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,869,694.4	1,864,569.1	(5,125.3)

Мөнгөн хөрөнгө

Тайлант оны эцсээр мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,809,246.5 мянган төгрөг байсан бөгөөд үүнээс 726,998.3 мянга төгрөг буюу 255.1 мянган ам.доллар нь Худалдаа хөгжлийн банкны 2691002235 тоот харилцах буюу төслийн тусгай дансанд, 627,868.7 мянган төгрөг нь Төрийн сангийн 100900011915 тоот төслийн дэд дансанд, 454,379.6 мянган төгрөг нь Төрийн сангийн 100900011812 тоот төслийн дэд дансанд тус тус байршиж байна. Мөнгөн хөрөнгө нь өмнөх оны үлдэгдлээс 45,332.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгө нь нийт 2,592.0 мянган ам.доллар буюу 7,353,027.7 мянган төгрөгийн санхүүжилтээр, хүүгийн орлого 2,830.7 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлого 95.3 мянган төгрөгөөр, гадаад валютын ханшийн олз 9,809.3 мянган төгрөгөөр тус тус өсч, төслийн үйл ажиллагаанд нийт 6,032,564.0 мянган төгрөг зарцуулагдсан байна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 55,322.6 мянган төгрөг болж 40,206.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд нийт 20,638.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар үндсэн хөрөнгө буурч, 2020 оны 4 сард нийт 52,669.8 мянган төгрөгийн Компьютер, тоног төхөөрөмжийн худалдан авалт, 8,175.1 мянган төгрөгийн офиссын тавилгын худалдан авалтаар тус тус үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 31,903.7 мянган төгрөг болж 29,505.1 мянган төгрөгөөр өссөн нь 2019 оны эцэст байсан байгууллагад өгөх өглөг 2,398.6 мянган төгрөгийг төлж, тайлант 2020 оны эцсээр төлөөгүй үлдсэн Хувь хүний орлогын албан татварын өглөг 3,774.6 мянган төгрөг, Канад Улсын зөвлөх үйлчилгээний Free Balance Inc байгууллагаас суутган тооцсон 28,129.1 мянган төгрөгийн ААНОАТ-ын өглөгийг тайланд тус тус хүлээн зөвшөөрснөөс өссөн байна.

Засгийн газрын оролцоо

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,832,665.4 мянган төгрөг болж 34,630.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант 2020 онд санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 34,630.3 мянган төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрснөөс болсон байна.

Орлого

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,267,337.5 мянган төгрөгөөр буюу 20.8 хувиар өссөн байна. Үүний гол шалтгаан нь төслийн санхүүжилтийн орлого нь өмнөх оноос 318.4 мянган ам.доллар буюу 1,277,455.1 мянган төгрөгөөр өссөн, хүүгийн орлого 10,212.9 мянган төгрөгөөр багассан, туслах үйл ажиллагаанаас орсон орлого 95.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Төслийн санхүүжилт нь 2019 онд 2,273.6 мянган ам.доллар буюу 6,075,572.6 мянган төгрөг, 2020 онд 2,592.0 мянган ам.доллар буюу 7,353,027.7 мянган төгрөг тус тус байсан.

Зардал

Нийт зардлыг харьцуулж үзэхдээ санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болон үйл ажиллагааны бус зардлын нийлбэрээс тооцсон бөгөөд нийт зардал нь өмнөх оноос 1,580,775.32 мянган төгрөгөөр буюу 27.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь “хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал” бөгөөд нийт 1,368,547.7 мянган төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,794,649.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 7,794,649.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн 5 бүрэлдэхүүн хэсгийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 7,794,649.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 7,353,027.7 мянган төгрөгийг гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаадын зээлийн эх үүсвэрээс 7,353,027.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлог 95.3 мянган төгрөг, нийт 7,353,123.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 7,411,095.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,411,095.0 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 6,133.4 мянган төгрөгөөр илүү зарцуулсан, хөрөнгийн зардлыг 384,146.5 мянган төгрөгөөр дутуу, байгууллагаас төлөх НДШ-ийн зардлыг 5,541.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 19 төрлийн 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 57 мэдээлэл, хугацаа хоцроосон 91 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Мөн төсөл нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу:

- Тайлант онд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 317 ширхэг 12,907,959.1 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлэх ёстой байснаас 109 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, 1,813,586.2 мянган төгрөгийн 208 гүйлгээг огт байршуулаагүй байна.
- Мөн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан 109 гүйлгээтэй холбоотой тушаал шийдвэрийг байршуулаагүй байна.

Төсөл нь эдгээр Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг биелүүлээгүй алдаа, зөрчлийг Аудитын явцад шилэн дансны цахим хуудсанд нөхөж оруулсан болно.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж байхгүй болно.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 402,322.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 136,022.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, аудитын явцад илэрсэн 266,299.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Төсөл нь 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр худалдан авсан 4 ширхэг нийт 1,544.6 мянган төгрөгийн оффисын тавилгыг хангамжийн зардлаар хүлээн зөвшөөрсөн байсныг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх залруулга хийлгэв.
2. Төслийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн яамд болон Монгол банканд актаар хүлээлгэн өгсөн нийт 49,317.0 мянган тоног төхөөрөмжийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд эдийн засгийн ангиллыг буруу илэрхийлснийг залруулсан.
3. Төсөл хариуцсан нэгжийн ажилтны 52,753.9 мянган төгрөгийн үндсэн цалингийн зардал болон НДШ-ийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд эдийн засгийн ангиллыг буруу илэрхийлснийг залруулсан.
4. Төсөл хариуцсан нэгжийн 4,278.0 мянган төгрөгийн оффисын түрээсийн зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд эдийн засгийн ангиллыг буруу илэрхийлснийг залруулсан.
5. Тайлант 2020 онд Канад улсын Free Balance Inc компанид төлсөн зөвлөх үйлчилгээний төлбөрөөс ААНОАТ-ын 5 хувийг суутган авч, харьяалагдах татварын байгууллагад төлөөгүй байсныг илрүүлж, 28,129.1 мянган төгрөгөөр татварыг тооцож, санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлээгүй алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг биелүүлээгүй алдаа зөрчил:
 - Төсөл нь "Шилэн дансны тухай" хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллээс 2020 онд нийт 19 төрлийн 149 мэдээг цахим хуудсанд байршуулахаас 148 мэдээг оруулж, 1 мэдээг оруулаагүй байна. Байршуулсан 148 мэдээнээс 57 нь хугацаандаа орж, 91 мэдээ нь хугацаа хоцорч орсон байна.

- 2020 онд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 12,907,959.1 мянган төгрөгийн 317 ширхэг мөнгөн гүйлгээг мэдээлэх ёстой байсан боловч 109 гүйлгээг мэдээлж, 1,813,586.2 мянган төгрөгийн 208 гүйлгээг мэдээлээгүй байна.
- 2020 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 109 мөнгөн гүйлгээний мэдээлэлд тайлант хугацааны орлого, зарлагын гүйлгээний дүн, утгын мэдээллийг оруулсан боловч холбогдох тушаал шийдвэрийн хуулбарыг хавсаргаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан заалтуудтай нийцэхгүй, мөн санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгсөн.

Аудитын зөвлөмж

Аудитын явцад илэрсэн 266,299.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд Сангийн Сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын дагуу Сангийн Яамны Санхүүгийн хяналт эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс хэрэгжүүлж буй төслийн хэрэгжилтийн үйл явцыг дүгнэх, төслийн гүйцэтгэл, үр дагавар, үр нөлөөг хэмжих хяналт шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) хийгдэж байна. Мөн Сангийн Яам болон Дэлхийн банкны зөвшилцлийн дагуу төслийн тусгай дансыг Төрийн санд шилжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

2020 онд төсөл нь нийт 1,368,547.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн төрийн байгууллагуудад шилжүүлсэн бөгөөд төслийн Бүрэлдэхүүн А болон В хэсгүүдийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд Сангийн яаманд нийт 1,128,722.4 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан, Бүрэлдэхүүн С хэсгийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороонд нийт 29,048.8 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан, мөн Бүрэлдэхүүн С хэсгийн хүрээнд Монгол банканд нийт 110,615.0 мянган төгрөгийн сервер, тоног төхөөрөмж худалдан авсан, Бүрэлдэхүүн D хэсгийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд нийт 100,161.5 мянган төгрөгийн архивын компьютер, тоног төхөөрөмж худалдан авч тус тус хүлээлгэн өгсөн байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Нэмэгдсэн өртгийн албан татвар**

1.1. Илрүүлэлт:

Төсөл нь тайлант онд хувь зөвлөхтэй 50 сая төгрөг ба түүнээс дээш үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний 1,807,600.4 мянган төгрөгийн 27 гэрээг байгуулсан боловч эдгээр гэрээний төлбөрийг шилжүүлсэн баримтад Е-баримтыг хавсаргаагүй, гэрээ байгуулсан зөвлөхүүдээс шаардаж аваагүй байна. Энэ нь тухайн зөвлөхүүд НӨАТ төлөгч болох хуулийн шаардлага хангасан боловч НӨАТ төлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн 50 саяаас доош үнийн дүн бүхий, НӨАТ төлөгч болоогүй хувь хүмүүст олгосон зөвлөх үйлчилгээний төлбөрөөс Е-баримт шаардаж аваагүй байна. Энэ нь эдгээр хувь хүмүүсийн Е-баримтны системд бүртгүүлэхгүй байх, цаашлаад татварын албанд хувиараа бизнес эрхэлж байгаа орлогоо тайлагнахгүй байх, нуун дарагдуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн тайлант онд гадаадын иргэн болон байгууллагатай зөвлөх үйлчилгээний 4 гэрээ байгуулснаас нийт 85,539.6 мянган төгрөгийн НӨАТ суутгаж, татварын албанд тайлагнаж төлөөгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох Монгол Улсын татварын хууль, тогтоомж зөрчигдөх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дараах заалтыг мөрдөж ажиллахыг зөвлөж байна. Үүнд:

4.1.6.а.-д "оршин суугч", гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 5.3-т заасан Монгол Улсад байнга байрладаг албан татвар төлөгч, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.3-т заасан Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийг;

4.1.6.б.-д "оршин суугч бус" гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 5.5, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.5-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгчийг;

4.1.8.-д "нэмэгдсэн өртгийн албан татвар суутгах үүрэг үүсэх өдөр" гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхэлж, орлого олж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрийг;

7.1.-д Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулна,

7.1.1.-д Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ,

7.2.5-д Оршин суугч бус этгээдийн оршин суугч этгээдэд борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ.

Мөн энэ хуулийн 17 дугаар зүйл 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасныг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- 1) Улсын Их Хурлаар баталсан Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Санхүүжилтийн хэлэлцээр"-т заасны дагуу Хүлээн

авагч тал худалдан авалтыг Дэлхийн банкны Худалдан авалтын журмыг дагаж мөрдөнө. Энэ журмын дагуу бие даасан зөвлөхүүдтэй гэрээ байгуулахдаа дараах заавар журмыг мөрдөж байна. Үүнд: Сангийн Сайдын 196 дугаар тушаалын 16.6.6-дахь "Төслийн зохицуулагч нь төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн шууд захирагчтай, санхүүгийн ажилтан болон худалдан авалт хариуцсан ажилтан нь Сангийн яамны төсвийн шууд захирагч болон төслийн захирал, төслийн зохицуулагчтай, бусад ажилтнууд нь төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн шууд захирагчтай болон төслийн зохицуулагчтай хөлсөөр ажиллах гэрээг гурвалсан хэлбэрээр байгуулна" - заалтын дагуу ТХН-ийн ажилтнуудаас бусад бие даасан зөвлөхүүд гурвалсан гэрээг байгуулдаг. Өөрөөр хэлбэл зөвлөхүүдийн гэрээний төлбөр нь НӨАТ-ын хуулийн 4.1.8-д заасан үйл ажиллагаа эрхэлж олсон орлого бус ХХОАТ-ын тухай хуулийн:

7 дугаар зүйл. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого,

7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна,

7.1.6. Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; -д хамаарагдана.

- 2) Мөн тухайн зөвлөхүүдийн орлогуудыг ХХОАТ-ын тухай хуулийн 7.1.6. үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого хэмээн орлогыг тодорхойлон холбогдох ХХОАТ суутгалыг суутган харьяа татварын албанд тайлагнадаг.

Иймд та бүхэн эдгээр зөвлөхүүд нь үйл ажиллагаа эрхэлж байгаа бус өөрсдөө биеэр ажиллаж цалин хөлс авч байгаа ажилтнууд болно.

- 3) Харин гадаадын Free Balance компаний хувьд бид Дэлхийн банканд танилцуулж НӨАТ-ыг суутган шилжүүлэхээр ажиллах болно.

2. Гадаад валютын бүртгэл

2.1. Илрүүлэлт:

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрөөс нэг өдрийн өмнөх Монгол банкны хаалтын ханшийг ашиглаж бүртгээгүй, өөр ханшаар бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тоот тушаал "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 25.1-т "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хүрээнд гадаад валютын гүйлгээг төгрөг рүү хөрвүүлэн бүртгэхдээ тухайн өдрөөс нэг өдрийн өмнөх Монгол банкны хаалтын ханшийг ашиглана" заалтыг биелүүлээгүй байна.

2.2. Эрсдэл:

Холбогдох стандарт, хууль, тогтоомж зөрчигдөх, ажил гүйлгээ нь НББ-д илүү болон дутуу тусгагдах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг зөв дүнгээр бүртгэх, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллахыг зөвлөж байна.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.20			САГ-2021/51/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн өдрөөс нэг өдрийн өмнөх Монгол банкны хаалтын ханшийг ашиглаж бүртгээгүй, өөр ханшаар бүртгэсэн байна.	-	Аудитын зөвлөмж өгөв	Төслийн зохицуулагч Төслийн нягтлан бодогч	Д.Батмөнх Б.Ундармаа
2	- Төсөл нь тайлант онд хувь зөвлөхтэй 50 сая төгрөг ба түүнээс дээш үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний 1,807,600.4 мянган төгрөгийн 27 гэрээг байгуулсан боловч эдгээр гэрээний төлбөрийг шилжүүлсэн баримтад Е-баримтыг хавсаргаагүй, гэрээ байгуулсан зөвлөхүүдээс шаардаж аваагүй байна. Энэ нь тухайн зөвлөхүүд НӨАТ төлөгч болох хуулийн шаардлага хангасан боловч НӨАТ төлөхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн 50 саяаас доош үнийн дүн бүхий, НӨАТ төлөгч болоогүй хувь хүмүүст олгосон зөвлөх үйлчилгээний төлбөрөөс Е-баримт шаардаж аваагүй байна. Энэ нь эдгээр хувь хүмүүсийн Е-баримтны системд бүртгүүлэхгүй байх, цаашлаад татварын албанд хувиараа бизнес эрхэлж байгаа орлогоо тайлагнахгүй байх, нуун дарагдуулах нөхцөлийг бүрдүүлж байна. - Мөн тайлант онд гадаадын иргэн болон байгууллагатай зөвлөх үйлчилгээний 4 гэрээ байгуулснаас нийт 85,539.6 мянган төгрөгийн НӨАТ суутгаж, татварын албанд тайлагнаж төлөөгүй байна.	266,299.7	Аудитын зөвлөмж өгөв	Төслийн зохицуулагч Төслийн нягтлан бодогч	Д.Батмөнх Б.Ундармаа
3	1) Төсөл нь "Шилэн дансны тухай" хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллээс 2020 онд нийт 19 төрлийн 149 мэдээг цахим хуудсанд байршуулахаас 148 мэдээг, оруулж 1 мэдээг оруулаагүй байна. Байршуулсан 148 мэдээнээс 57 нь хугацаандаа орж, 91 мэдээ нь хугацаа хоцорч орсон байна. 2) 2020 онд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 12,907,959.1 мянган төгрөгийн 317 ширхэг мөнгөн гүйлгээг мэдээлэх ёстой байсан боловч 109 гүйлгээг мэдээлж, 1,813,586.2 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй байна. 3) 2020 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 109 мөнгөн гүйлгээний мэдээлэлд тайлант хугацааны орлого, зарлагын гүйлгээний дүн, утгын мэдээллийг оруулсан боловч холбогдох тушаал шийдвэрийн хуулбарыг хавсаргаагүй байна.	-	Албан шаардлага өгөв	Төслийн зохицуулагч Төслийн нягтлан бодогч	Д.Батмөнх Б.Ундармаа
ДҮН		266,299.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 124/АД160057

Улаанбаатар хот

САГ-2021/51/СГА-ТХН

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 2020 онд нийт 19 төрлийн 149 мэдээг цахим хуудсанд байршуулахаас 148 мэдээг оруулж, 1 мэдээг оруулаагүй байна. Байршуулсан 148 мэдээнээс 91 мэдээг хугацаа хоцроосон байна. Мөн Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 317 мөнгөн гүйлгээнээс 109 гүйлгээг мэдээлж, 208 гүйлгээг огт мэдээлээгүй, эдгээр мэдээлсэн 109 орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой тушаал шийдвэрийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр-г мэдээлнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг төслийн зохицуулагч Д.Батмөнх, төслийн нягтлан бодогч Б.Ундармаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
ГРАНТ ТӨРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Л.НЯМТӨМӨР

Э.ШИЖИРТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 28 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.